



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

**Г Гадаадад сургалтын төрийн сангийн  
зээлээр суралцуулах тухай**

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 тоот тогтоолоор баталсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар баталсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төмөрхүү овогтой Мягмарсүрэнг АНУ-ын Бриджпорт их сургуульд Бизнесийн удирдлага, менежментийн чиглэлээр магистрантурт 2 жил, Лхагвасүрэн овогтой Намууланг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын захиалгаар Малайз улсын Куала-Лумпур хотын Мультимедиа их сургуульд бизнесийн удирдлагын менежмент, олон нийттэй харилцах чиглэлээр бакалаврын сургалтанд 3 жил, Төмөрбаатар овогтой Баасанпүрэвийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиалгаар Австрали улсын Технологийн Curtin их сургуульд шинжлэх ухааны магистрийн чиглэлээр 1,5 жил, Равдан овогтой Цолмонг Австрали улсын Charles Sturt их сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр магистрантурт 1,5 жилээр тус тус суралцуулсугай.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР